

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН САЛБАР ДАХЬ ТАСРАЛТГҮЙ БОЛОВСРОЛ БА ШАТАЛСАН СУРГАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

Ц.Цэцэгсүрэн

15-р сургууль

XXI зуунд боловсрол цоо шинээр өөрчлөгдөх болсон. XX зууны төгсгөл, XXI зуун нь мэдээллийн технологийн үсрэнгүй хөгжлийн үе Технологийн эрс шинэчлэлийн үе, Оюун санааны үсрэнгүй хөгжлийн үе.

Энэ бүгд нь нийгмийг өөрчлөх, боловсролын тогтолцоог шинэчлэх шаардлагатай болсон. Боловсролын шинэчлэлийн үндэс нь боловсролыг үзэх үзэл өөрчлөгдсөн.

Боловсрол бол зөвхөн түүнийг эзэмшихийн төлөө байдаггүй. Хүнийг бүх талаар нь хөгжүүлэх бүтээлч үйл ажиллагааны туршлага эзэмшүүлэх, өмнөх үеийн хуримтлуулсан хөдөлмөрийн арга барилтай танилцуулах авьяас чадварыг нь хөгжүүлэх энэ утгаар боловсрол нь бие даан хүнийг хөдөлмөр танин мэдэхүй, харилцааны идэвхтэй субъект болгон хөгжүүлэх зорилготой болж байна.

Тасралтгүй боловсрол .

- 1968 онд НҮБ-ийн боловсрол, шинжлэх ухааны, соёлын байгууллагын Ерөнхий бага хурлын материалд анх дурдагдсан бөгөөд 1972 онд тасралтгүй боловсролын үзэл санааг тусгасан “Форын илтгэл” гэдэг баримт бичиг хэвлэгдсэн байна.
- Үүнд “Тасралтгүй боловсролын гол үзэл санаа нь хүн бүр хэрэгцээт боловсролоо өөртөө тохиромжтой хэлбэрээр, бололцоотой цагтаа эзэмших эрх, нөхцөлөөр хангагдсан түүнийг нь хэрэгжүүлэх тогтолцоо бүрдсэн байх явдал юм” гэжээ.
- Тасралтгүй боловсролын гол үзэл санаа
- Хүнийг үйл ажиллагаа, харилцааны субъект гэж үзэж түүний бүх талын хөгжлийг насан туршид нь хангах явдал гэж үзэж байна. Тасралтгүй боловсролын онол нь шаталсан сургалтын онол юм.

Шаталсан сургалт

- Шаталсан сургалт бол сургалтын агуулга, стандартын хувьд хоорондоо нягт залгамж холбоо бүхий үе шатуудаар дамжуулан боловсрол олгож мэргэжилтэн бэлтгэдэг сургалтын нэг хэсэг.
- Тасралтгүй боловсролын онолд сургалтыг либералчлахыг чухал болгосноор шаталсан сургалттай гүн холбогдож байна.
- Сургалтын төвд сурагч байх, нийгмийн антропологийн үзлийг чухалчлах
- Сургалтын хэтийн төлөвийг олон хувилбартай болгох
- Мэргэжил хооронд шилжих сургалтын орчныг бүрдүүлэх

Ерөнхий боловсролын сургуульд шатлал байна гэж үзэж байна. ЕБС-д одоогийн байгаа хослолыг авч үзье. Үүнд:


Сургуулийн хослол

- А хувилбар: X-XI /XI-XII/ ангитай ахлах сургууль, YI-IX/YII-X/ ангитай дунд сургууль, I-Y/I-YII/ ангитай бага сургууль,
- Б хувилбар: X-XI/ XI-XII/ ангитай ахлах сургууль, YI-IX/YII-X/ ангитай дунд сургууль,
- В хувилбар: YI-IX/YII-X/ ангитай дунд сургууль, I-Y/I-YII/ ангитай бага сургууль,
- Г хувилбар: Цэцэрлэг, I-Y/I-YII/ ангитай бага сургууль,
- Д хувилбар: Цэцэрлэг, I-IX ангитай дунд сургууль
- Е хувилбар: Ахлах лицей, /X-XI/, дээд сургууль,
- Ё хувилбар: Дунд, ахлах бүлэгтэй лицей /YI-XI/, дээд сургууль,
- Ж хувилбар: ЕБС, МСҮ Төв

Цогцолбор сургууль						
№	Нэгдсэн сургуулийн тоо	Сургуулийн тоо	Сурагчийн тоо	Багшийн тоо	Сурагчийн дундаж тоо	Багшийн дундаж тоо
1	1 сургууль	29	684-3585	23-127	2072	77
2	2 сургууль нийлсэн	9	662-3386	51-93	2590	103
3	3 сургууль нийлсэн	5	3186-6155	67-203	4882	129
4	5 сургууль нийлсэн	1	4651	171	4651	171
5	7 сургууль нийлсэн	1	10609	403	10609	403

ЕБС-ийн хэв шинж				
№	Сургуулийн нэр	Тоо	Үүнээс	
			Төрийн	Төрийн бус
1	Ахлах сургууль	397	329	68
2	Дунд сургууль	252	205	47
3	Бага сургууль	75	51	24
	Нийт	724	585	139

№	Сургуулийн нэр	Тоо	Үүнээс	
			Төрийн	Төрийн бус
1	Ахлах сургууль	397	329	68
2	Дунд сургууль	252	205	47
3	Бага сургууль	75	51	24
		724	585	139



Дүгнэлт

- Тасралтгүй боловсролын онолыг нэвтрүүлэх нэг хэлбэр нь ЕБС-д шаталсан сургалтын онол арга зүйг нэвтрүүлэх, судалж хэрэгжүүлэх явдал юм.
- ЕБС-д цогцолбор сургууль бий болж сургуулиудыг нэгтгэх нь сургуулийн удирдлагыг төвлөрүүлэх нэгэн хувилбар болсон
- ЕБС-ийн салбарт Азийн хөгжлийн банкны шугамаар цогцолбор сургууль байгуулахаар төсөл хэрэгжүүлсэн нь ЕБС-ийн удирдлагыг боловсронгуй болгох зохион байгуулалтын нэг хэлбэр болсон.

Дээрх судалгаанаас үзэхэд 45 сургуулийг цогцолбор сургууль болгон зохион байгуулсан нь шаталсан сургалтыг нэвтрүүлэх хувилбар болсон байна.